



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Нийслэлийн Ерөнхий боловсролын
75 дугаар сургуулийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэн, аж ахуйн нэгжүүдээс хандивласан нийт 50,663,000 (тавин сая зургаан зуун жаран гурван мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг нийслэлийн Ерөнхий боловсролын 75 дугаар сургууль (Д.Тунгалаг)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг нийслэлийн Ерөнхий боловсролын 75 дугаар сургууль (Д.Тунгалаг)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

1150500051

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны 04 дүгээр сарын 25 -ны өдрийн
А/35 дугаар тушаалын хавсралт

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн Ерөнхий боловсролын 75 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1.Тавилга эд хогшил										
1	Багш ширээ /тумбо/	модон	2022.02.22	сайн	ком	3	350,000.00	1,050,000.00	Шунхлай групп	Хандив
2	Багш сандал	модон	2022.02.22	сайн	ш	3	85,000.00	255,000.00		
3	Сурагч ширээ сандал урт	модон	2022.02.22	сайн	ком	75	250,000.00	18,750,000.00		
4	Сурагч ширээ сандал урт	модон	2022.02.22	сайн	ш	25	250,000.00	6,250,000.00	Интермед эмнэлэг	
5	Гадна талбайн сандал	модон	2022.06.23	сайн	ш	10	380,000.00	3,800,000.00		
6	Сурагч ширээ сандал урт	модон	2022.08.29	сайн	ком	25	280,000.00	7,000,000.00	МАК	
7	Багш ширээ /тумбо/	модон	2022.08.29	сайн	ш	1	350,000.00	350,000.00		
8	Багш сандал никель хөлтэй	модон	2022.08.29	сайн	ш	1	95,000.00	95,000.00	Э.Мөнх-Очир	
9	Багш ширээ /тумбо/	модон	2022.08.25	сайн	ш	1	350,000.00	350,000.00		
10	Багш сандал	модон	2022.08.25	сайн	ш	1	95,000.00	95,000.00		
11	Сурагч ширээ сандал урт	модон	2022.08.25	сайн	ком	25	250,000.00	6,250,000.00		
Тавилга эд хогшлын дүн						170		44,245,000.00		
2. Тоног төхөөрөмжийн дүн										
12	Жигнүүр	төмөр	2022.08.29	Сайн	ш	1	1,230,000.00	1,230,000.00	Интермед эмнэлэг	
13	Махны машин	төмөр	2022.08.29	Сайн	ш	1	888,000.00	888,000.00		
14	2-р хоолны тогоо	төмөр	2022.08.29	Сайн	ш	1	4,300,000.00	4,300,000.00		
Тоног төхөөрөмжийн дүн						3		6,418,000.00		
Нийт бүртгэх хөрөнгийн дүн						173		50,663,000.00		